

"АЗИЙН САН" БА МОНГОЛ ДАХЬ ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

О.Гэрэлтуяа

"Азийн сан" хэмээх байгууллага нь 1954 онд байгуулагдсан юм. 40 дахь хаврынхаа нүүр үзэх гэж буй энэ байгууллага буян үйлдэж, тусламж үзүүлэх аруун зорилтыг эрхэмлэдэг билээ. Тэрээр байгуулагдсан цагаасаа хойш Америк, Азийн орнуудын хооронд найрсаг харилцаа, харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ази Номхон далайн орнуудад өрнөж буй ардчилалын үйл явцыг хөхүүлэн дэмжихэд хүчин зүтгэсээр ирсэн түүхтэй.

"Азийн сан" нь АНУ-ын Калифорни мужийн үзэсгэлэнт Сан-Франциско хотод байрладаг бөгөөд эдүгээ Ази, Номхон далайн бүс нутгийн 30 гаруй орны засгийн газрын хийгээд засгийн газрын бус байгууллагуудтай хамтран олон мянган төсөл төлөвлөгөө хэрэгжүүлж байна.

"Азийн сангийн" үйл ажиллагааг АНУ-ын нэр хүнд бүхий улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүдээс бүрдсэн Зөвлөл удирдах бөгөөд түүний төв аппарат болон Ази, Номхон далайн бүс нутгийн 13 орон дахь төлөөлөгчийн газарт мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн ажилтнууд ажилладаг юм. Энэ байгууллага нь АНУ болон Ази, Номхон далайн бүс нутгийн олон орны засгийн газрын болон хувийн, арилжааны болон хандивийн, үйлдвэрлэл үйлчилгээний болон тусламжийн байгууллагуудын санхүү, эдийн засаг, зохион байгуулалтын тусламж дэмжлэгэд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Түүнчлэн жил бүр АНУ-ын Конгресс болон Олон улсын хөгжлийн агентлагийн шугамаар тодорхой төсөл хэрэгжүүлэх зориулалт бүхий төсөл хөрөнгө улсаас гаргуулан авч байх эрхтэй юм. "Азийн сан"-гийн үйл ажиллагааны гол гол чиглэлийн талаар товч дурдвал: үүнд:

- Ардчилсан өс. байгууламжийг дэмжих үүднээс "Азийн сан" нь сонгуулийн болон олон нийтийн үүсгэл санаачлагын, шүүхийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох үйлсэд давын өмнө туслах ёстой хэмээн үздэг байна. Эдгээр чиглэлээр тэрээр хууль тогтоомжийн боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, хүн сургах, дадлага туршлагыг нь нэмэгдүүлэх зорилгоор мэргэжилтэн ирүүлэх, курс семинар, туршлага судлах, аялал зохион байгуулах зэрэг хэлбэрийн ажил зохиодог. Түүнчлэн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, нийгмийн амьдралд оролцох тэдний оролцоог өргөжүүлэх, эд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, байгаль орчны бохирдолттой тэмцэх зэрэг чиглэлээр хамтран ажилладаг юм.

- Зах зээлийн эдийн засгийн тогтолцоог төлөвшүүлэн хөгжүүлэх үүднээс "Азийн сан" нь мөн олон хэлбэрийн төсөл хэрэгжүүлдэг. Тухайлбал, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих эрх зүйн үндсийн бүрдүүлэх, бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн хэлхээ холбоог өргөжүүлэх хөгжүүлэхэд эдийн засагчдийн уулзалт зохион байгуулах зэрэг ажилд бололцооныхоо хирээр туслахыг хичээдэг юм.

- Бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд туслах үүднээс "Азийн сан" нь тус бүс нутгийн орнуудын хоёр талын хийгээд олон талын харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх, бүс нутгийн олон улсын байгууллагуудын нэрхүнд, үйл ажиллагааных нь үр ашгийг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэн ажилладаг болно. Чингэхдээ, бүс хэмжээний хурал, уулзалт, солилцооны хөтөлбөр болон тодорхой байгууллагуудын үйл ажиллагааг тэтгэн дэмждэг юм.

(Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын Ерөнхий Атторней нарын бага хурал, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудын эмэгтэйчүүдийн чуулга уулзалт зэрэг байгууллага)

- Ном хандивлан нийлүүлэх төслүүдийн хүрээнд "Азийн сан" нь жилдээ 1 сая гаруй ном товхимол болон сонин сэтгүүлийг тус бүс нутгийн орнуудын байгууллагуудад (Их, дээд, дунд сургууль, номын сан, судалгааны төв, хүрээлэн г.м.) үнэ төлбөргүй илгээдэг. Эдгээр ном товхимол, сонин сэтгүүл нь англи хэл дээр байх бөгөөд хүсэлт тавьсан талын захиалгаар тодорхой сэдэв, чиглэлээр сонгогдон түүвэрлэгдсэн байдаг журамтай. Эдгээр ном зохиол, сонин сэтгүүлийн жагсаалтыг "Азийн сан"-гийн шугамаар захиалан авч болно.

Монгол улстай "Азийн сан" нь 1990 оноос харилцаа тогтоож хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд Улсын Бага хурал, Улсын Их хурал, Засгийн газар, Улсын дээд шүүх, Үндэсний их сургууль, Байгаль орчныг хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагуудтай хамтран олон төрлийн төсөл хэрэгжүүлсээр ирлээ. Эдгээр төслийн хүрээнд шинэ Үндсэн хууль, болон ардчилал, ах зээлийн харилцаанд шилжихэд нэн чухал бусад хуулийн төсөл боловсруулахад тусалцаа дэмжлэг үзүүлэх, өндөр мэргэжлийн зөвлөх шинжээчийг Монгол улсад томилон ажиллуулах, монголын талын хүмүүст зориулсан туршлага судлах, аялал зохион байгуулах, ном зохиол, лавлах материал нийлүүлэх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлжээ.

"Азийн сан" нь Монгол улсын Засгийн газрын бус байгууллагуудтай хэрэгжүүлэх хамтын ажиллагаагаа цаашид ч өргөжүүлэх сонирхолтой байгаа бөгөөд улмаар энэхүү хамтын ажиллагаа нь Монгол улсын ардчилсан ёс, зарчим, зах зээлийн харилцааг бататган хөгжүүлэх буянтай үйлсэд чиглэгдэх юм.